



2023 оны 7 дугаар сарын 19

Мөшгөлтийн тогтолцооны Удирдамж

(хувилбар 3.1)



ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛ

Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Энэхүү баримт бичигт тайлбарласан мөшгөлтийн тогтолцоо, үйл явцын байнгын уялдааг хангахын тулд тус удирдамжийг жил бүр хянадаг болно.

Хуудасны дугаар	Агуулга	Өөрчлөлт	Огноо
Хувилбар 3.0	Монгол болон Хятадад мөрдөгддөг удирдамжийн баримт бичгийг нэгтгэн нэг баримт бичиг болгон хөгжүүлэв.	Удирдамжийн нэр томъёоны тайлбар тольд 'SFA Certified' ноолуурын агууламжийн мэдэгдэл 100% болж шинэчлэгдсэн. Энэ нь шинэ SFA Cashmere Standard-г дагаж мөрдөхөд орж буй шинэчлэлт юм. Зааварчилгаатай харьцуулах замаар шаардлагуудыг тодруулсан. Давхардлыг арилгасан. Лавлагаа баримт бичгийн цахим холбоосыг оруулсан.	19/06/2023
Хувилбар 3.1	Тодруулга, санал хүсэлтийг бүртгэж, Брэндийн удирдамжийг тусган, хэвлэлийн алдааг залруулав.	Ноолуурыг холих он цагийн хуваарь дээр нэмэлт зааварчилгаа оруулсан. "Мэдэгдэл гаргах зөвлөмж"-д үйл явц болон тодорхойлолтын мэдээллийг төвлөрүүлэн шинэчилж, харин энэхүү баримт бичгийн 4.1 Мэдэгдлийн удирдамж хэсэгт мэдэгдлийн дүрэмтэй холбоотой хэсгийг шилжүүлэв. Алдааг залруулж, бусад тодруулыг нэмж оруулсан.	19/07/2023

Нэр томьёоны тайлбар толь

Нэр томьёо	Тодорхойлолт
Багц	Нэг буюу хэд хэдэн оролтын эх үүсвэрийг ашиглан боловсруулсан эсхүл үйлдвэрлэсэн ноолуур, ноолууран бүтээгдэхүүний гаралтын тоо хэмжээ.
Брэнд/жижиглэн худалдаалагч	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ба/эсвэл хэрэглэгчдэд борлуулдаг аж ахуйн нэгж.
Баталгаажуулалт	Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний тогтолцоо нь тодорхой шаардлагад нийцэж байгаа тухай албан ёсны үйл явцаар бичгээр баталгаа (сертификат) олгох.
Мөшгөлтийн тогтолцоо (CoC)	Сонгосон түүхий эдээс эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх худалдаа, үйлдвэрлэлийн бүх үе шатыг баримтжуулах, баталгаажуулах систем. CoC нь түүхий эдийн тодорхойлолтыг хадгалдаг болно.
Мэдэгдэл	Бүтээгдэхүүний агууламжид 'SFA Certified' ноолуур байгаа эсэхтэй холбоотой олон нийтэд болон худалдан авагчдад танилцуулдаг аман болон бичгэн, далд утгаар илэрхийлсэн мэдэгдэл, зар сурталчилгаа болон бусад төрлийн харилцааны хэлбэр.
Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)	Олон улсын итгэмжлэлийн форумын (ILA) Олон талт хэлэлцээрт (MLA) гарын үсэг зурсан итгэмжлэлийн байгууллагаас тохирлын үнэлгээний үйл ажиллагаа явуулах үр чадварыг нь баталгаажуулсан байгууллага.
Агууламжийн мэдэгдлийн стандарт (АМС)	'Textile Exchange' байгууллагын хөгжүүлж эзэмшдэг мөшгөлтийн тогтолцооны стандарт, энэ нь эцсийн бүтээгдэхүүнд нэг эсвэл хэд хэдэн түүхий эдийн орцод баталгаа гаргах аргачлалыг компаниудад олгодог.
Хэрэглэгч	Хувийн хэрэгцээнд зориулж бараа, үйлчилгээ худалдан авдаг хувь хүн эсвэл бүлэг хүмүүс.
Ширхэгт	Өөрөөр заагаагүй бол ноолууран ширхэгтийг тусгайлан хэлнэ.
Анхан шатны боловсруулах үйлдвэр	Ноолуурын эхний шатны ("анхдагч") боловсруулалт, тухайлбал түүхий ноолуурыг ангилах, угаах болон/эсвэл самнах зэрэгт оролцдог боловсруулах байгууламжууд.
Бэлтгэн нийлүүлэгчид	Ноолуур үйлдвэрлэдэг, бэлтгэдэг аж ахуйн нэгж.
Үйлдвэрлэгч	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж.
Хамрах хүрээний гэрчилгээ (SC)	Хамрах хүрээний гэрчилгээ (SC) нь зөвшөөрөгдсөн тохирлын үнэлгээний байгууллагаас холбогдох стандартын шаардлагыг дагаж мөрдөх чадварыг нотолсон компаниудад олгосон баримт бичиг юм. Хамрах хүрээний гэрчилгээ эзэмшигч нь "SFA Certified" ноолуур боловсруулж борлуулах эрхтэй.
'SFA Certified' ноолуур	Мөшгөлтийн тогтолцоо нь ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоо ба/эсвэл 'Textile Exchange'-н Агууламжийн мэдэгдлийн стандартаар баталгаажсан, SFA Cashmere Standard ба/эсвэл ТННЭ-ийн Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадлын стандартын дагуу үйлдвэрлэсэн ба/эсвэл боловсруулсан ноолуур.
Нийлүүлэлтийн сүлжээ	Түүхий эдээс эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэл материал, бараа, үйлчилгээ нийлүүлэх, худалдан авах үйл ажиллагаанд оролцож буй бизнесийн байгууллагуудын дараалал.
Борлуулалтын баримт (ББ)	Борлуулж буй бүтээгдэхүүний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл (гүйлгээ хийсэн огноо, өнгө, жин, төлөв гэх мэт) болон материалыг худалдагч, худалдан авагчийн холбоо барих мэдээллийг агуулсан, худалдагч талаас худалдан авагчид олгосон баримт бичиг.
Борлуулалтын гэрчилгээ (БГ)	Нэг байгууллагаас нөгөөд борлуулж, тээвэрлэж буй бүтээгдэхүүн нь тухайн стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор тохирлын үнэлгээний байгууллагаас гаргасан баримт бичиг бөгөөд хүлээн авагч нь "SFA Certified" ноолуур гэж үзэж болно.
Хувь хэмжээг тохируулах тооцоолол	Нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүрд хөрвүүлэх хувь хэмжээг (бүтээгдэхүүн хасах хаягдал) авч үзэхийн тулд 'SFA Certified' ноолуурт агуулагдах оролт ба гаралтын тэнцвэрт байдалд хяналт тавих үйл явц.

АГУУЛГА

АГУУЛГА.....	4
1 ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1. Мөшгөлтийн тогтолцооны удирдамж.....	5
2 ХАМРАХ ХҮРЭЭ.....	6
2.1. ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны хамрах хүрээ.....	6
3 МӨШГӨЛТИЙН ТОГТОЛЦОО.....	8
3.1. Борлуулалтын шаардлага.....	8
3.2. ТННЭ-ийн мөшгөлтийн удирдлагад тавигдах шаардлага.....	10
4 МЭДЭГДЭЛ ГАРГАХ.....	11
4.1 Мэдэгдлийн удирдамж.....	11
5 НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ.....	13
ХАВСРАЛТ –.....	14
БОРЛУУЛАЛТЫН БАРИМТУУД.....	14

1 ТАНИЛЦУУЛГА

1.1. Мөшгөлтийн тогтолцооны удирдамж

Мөшгөлтийн тогтолцоо нь баталгаажсан бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний дагуу явж буй үл мөрийг мөшгөх, бүртгэл хөтлөх үйл явц юм. ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны (SFA CoC) удирдамж нь ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний дагуу ТННЭ-ийн мөшгөх тогтолцооны хөтөлбөрт оролцож байгаа болон "SFA Certified" ноолуур, ноолууран бүтээгдэхүүн худалдан авах, худалдах компаниудад тавигдах шаардлагуудыг тодорхойлсон.

ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоо нь цахим мөшгөлтийн хяналтын программ хангамжаас гадна борлуулалтын баримт болон борлуулалтын гэрчилгээнээс бүрдэх цаасан суурьтай системийг ашигладаг. Энэхүү мөшгөх системийг уг удирдамжийн дагуу ноолууртай харьцах, үнэн зөв бүртгэл хөтлөхийн тулд оролцогч компаниуд өөрийн мөшгөлтийн системтэй хамт ашиглаж болно.

ТННЭ нь 2024 оны 7-р сарын 1 гэхэд 100% "SFA Certified" ноолуурын агууламжтай байх загварыг нэвтрүүлэх гэж байна. Энэ загвар нь баталгаажуулсан бүтээгдэхүүнийг баталгаажуулаагүй бүтээгдэхүүнээс, эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх ханган нийлүүлэлтийн үе шат бүрд биечлэн тусгаарлах шаардлагыг багтаасан. "SFA Certified" ноолуурыг баталгаажуулаагүй ноолууртай холихыг хориглоно. Уг Мөшгөлтийн загвар нь эцсийн бэлэн бүтээгдэхүүнд хэрэглэгдсэн ноолуур нь 100% "SFA Certified" гэдгийг баталгаажуулах бөгөөд эцсийн хэрэглээний тодорхой мэдэгдэл гаргах боломжийг олгох юм.

Хэрэв ноолууран бус бусад ширхэгтэй холих тохиолдолд эцсийн бүтээгдэхүүн дэх "SFA Certified" ноолуурын агууламж хамгийн багадаа 5% байх ёстой.

2023 оны 7-р сарын 1-ээс эхлэн "SFA Certified" ноолуурыг баталгаажуулаагүй ноолууртай холих БОЛОМЖГҮЙ.

'SFA Certified' ноолуур нь 2024 оны 7-р сарын 1 гэхэд эцсийн бүтээгдэхүүнд агуулагдах нийт ноолуурын агууламжийн 100% байх ёстой.



2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны хамрах хүрээ

'SFA Certified' ноолуурт зориулсан Мөшгөлтийн системийг тухайн аж ахуйн нэгжээс хамааран ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоо (SFA CoC) эсвэл Textile Exchange байгууллагын Агууламжийн мэдэгдлийн стандарт (AMC)-аар дамжуулан хийж ирсэн (Зураг 1).

ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоо нь Хятад болон Монгол улсад хийгдэж буй түүхий ноолуурын борлуулалт, эсвэл гүн боловсруулалтанд оруулах зориулалтаар экспортлогдох, Монгол Улсад самнасан ноолуурын бүх борлуулалтыг хамардаг. Мөн боловсруулах үйлдвэрийн төлөөлөгчид эсвэл бие даасан арилжаа эрхлэгчид ноолуурыг орон нутгаас цуглуулж, угааж, самнах зорилгоор анхан шатны боловсруулах үйлдвэр рүү тээвэрлэхэд хамаарна. Үүнээс гадна Монголд хийгдэж буй ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг мөн ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоонд хамруулдаг.

Агууламжийн мэдэгдлийн стандарт (AMC) нь бусад бүх борлуулалтыг багтаасан бөгөөд үүнд Монгол Улсаас гаднах үйлдвэрлэлийн аливаа үйл явц (ээрэх үе шатнаас эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэл) багтдаг. Монгол Улсаас гадна байгаа Агууламжийн мэдэгдлийн стандартын хамрах хүрээний компаниуд нь 'SFA Certified' ноолуурт зориулсан уг стандартыг дагаж мөрдөх бөгөөд хүчинтэй Хамрах хүрээний гэрчилгээ (SC)-тэй байх шаардлагатай. Энэ нь ТННЭ-д баталгаажсан ноолуурыг Монголоос гаднах нийлүүлэлтийн сүлжээгээр мөшгөх боломжийг олгодог. AMC-ын хамрах хүрээний гэрчилгээ болон/эсвэл борлуулалтын гэрчилгээтэй холбоотой аливаа асуултыг AMC-ын баталгаажуулалтын байгууллагад илгээнэ үү.



Агууламжийн мэдэгдлийн стандартын шаардлагууд болон хэрхэн баталгаажуулах талаар [энэхүү линкнээс дэлгэрэнгүй уншиж танилцана уу.](#)

- 2.1.1 ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоонд оролцогч бүх бэлтгэн нийлүүлэгч, анхан шатны боловсруулах үйлдвэр, брэнд үйлдвэрлэгчид [Мөшгөлтийн тогтолцооны бүртгэлийн маягыг](#) бөглөж ТННЭ-д бүртгүүлнэ.
- 2.1.2 ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоонд оролцогч бүх анхан шатны боловсруулах үйлдвэр, брэнд үйлдвэрлэгчид Мөшгөлтөнд оролцох хураамжийг төлсөн байна.
- 2.1.3 ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоонд оролцогч бүх компаниуд өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй улс, засаг захиргааны бүхий л хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөнө.
- 2.1.4 ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоонд оролцогч бүх бэлтгэн нийлүүлэгчид [SFA Cashmere Standard](#) (эсвэл 2023 оны 12-р сарын 31-нээс өмнө бол түүний өмнөх аль нэг) стандартын гэрчилгээтэй байна.
- 2.1.5 ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоонд оролцогч бүх анхан шатны боловсруулах үйлдвэр нь [Цэвэр ноолуур боловсруулах стандартын](#) гэрчилгээтэй байна.



Худалдагч тал нь холбогдох бүх стандарт ба/эсвэл Зохистой дадлын шаардлагыг хангасан тохиолдолд ноолуур нь "SFA Certified" болно. Бүх талууд аудитын зардлаа өөрсдөө хариуцна гэдгийг анхаарна уу.

Зураг 1: 'SFA Certified' ноолуурын мөшгөлтийн систем

Монгол дахь компаниуд

ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоо

- ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны аудитад орж, гэрчилгээ авсан байх шаардлагатай.
- Монгол Улсын хэмжээнд хийгдэж буй бүх борлуулалт нь ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоог дагаж мөрдөх бөгөөд зөвшөөрөгдсөн Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-р баталгаажсан байх ёстой.

Монгол улсаас самнасан ноолуурыг экспортлох

ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоо

Монгол Улс дахь ТННЭ-д бүртгэлтэй мөшгөлтийн тогтолцооны оролцогчид болон Монгол Улсаас гаднах ТННЭ-д бүртгэгдсэн олон улсын оролцогчдын хооронд хийгдсэн бүх гүйлгээ нь ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны хүрээнд явагдах бөгөөд зөвшөөрөгдсөн ТҮБ-аар баталгаажуулсан байх ёстой.

Агууламжийн мэдэгдлийн стандарт

Монгол Улсаас гаднах бүх гүйлгээ нь Агууламжийн мэдэгдлийн стандарт (АМС)-д (нэр томъёоны тайлбараас үзнэ үү) хамаарах бөгөөд зөвшөөрөгдсөн ТҮБ-аар баталгаажуулсан байх ёстой.

Хятад улсаас авсан ноолуур

ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоо

Анхан шатны боловсруулах үйлдвэрийг оруулалгүй ТННЭ-д бүртгэлтэй компаниудын хооронд хийгдсэн бүх түүхий ноолуурын борлуулалт нь ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоонд хамаарах бөгөөд зөвшөөрөгдсөн ТҮБ-аар баталгаажуулсан байх ёстой.

Агууламжийн мэдэгдлийн стандарт

Цаашдын бүх борлуулалт нь Агууламжийн мэдэгдлийн стандартад хамаарах бөгөөд зөвшөөрөгдсөн ТҮБ-аар баталгаажуулсан байх ёстой.

3 МӨШГӨЛТИЙН ТОГТОЛЦОО

Уг бүлэгт "SFA Certified" ноолуур болон ноолууран бүтээгдэхүүн худалдаалах хүсэлтэй ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний компаниудад тавигдах шаардлагыг тодорхойлсон. Үүнд ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоогоор баталгаажсан ноолуурыг хэрхэн хадгалах, тээвэрлэх, худалдаалах талаар тавигдах шаардлагууд болон ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоонд оролцогчдын мөрдвөл зохих Мөшгөлтийн Удирдлагын тогтолцоонд тавигдах шаардлагыг багтаасан болно.

3.1. Борлуулалтын шаардлага

- 3.1.1 Тухайн ААН, Компани нь зөвхөн хүчинтэй Хамрах хүрээний гэрчилгээтэй эсвэл ТННЭ-ийн гишүүн байгууллагуудаас 'SFA Certified' ноолуурыг худалдан авна.
- 3.1.2 Тухайн ААН, Компани нь самнасан "SFA Certified" ноолуурыг ТННЭ-ээс бичгээр зөвшөөрөл авалгүйгээр нээлттэй зах зээлд арилжаалах боломжгүй.
- 3.1.3 Тухайн ААН, Компани нь боловсруулах болон үйлдвэрлэх үе шатанд "SFA Certified" ноолуурыг баталгаажуулаагүй ноолуураас (2023 оны 7-р сарын 1-ээс өмнө хольсноос бусад) тусад нь байлгана.
- 3.1.4 Бүтээгдэхүүнд агуулагдаж буй нийт ноолууран ширхэгтийн 33% нь "SFA Certified" ноолуур байхаас бусад тохиолдолд компани бүтээгдэхүүнээ "SFA Certified" гэж худалдахгүй.



Энэхүү шаардлагыг 2024 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүйд тооцож 3.1.6-г мөрдөх болохыг анхаарна уу.

- 3.1.5 Компани нь 2023 оны 7-р сарын 1-ээс хойш "SFA Certified" ноолуурыг баталгаажуулаагүй ноолууртай хольж болохгүй.



Бүтээгдэхүүн дэх ноолуурын 33%-иас доошгүй хувь нь "SFA Certified" ноолуурыг одоо байгаа бусад ноолууртай хольж болно. Холио хийгдсэн бүтээгдэхүүний "SFA Certified" ноолуурын хувь хэмжээ нь нэмж холих гэж буй "SFA Certified" ноолуурын агууламжтай адил юм уу хамгийн бага зөвшөөрөгдөх хувиас их байх ёстой. Өөр өөр бэлтгэн нийлүүлэгчдээс авсан "SFA Certified" ноолуурыг хольж болно.



Энэ нь нийлүүлэлтийн сүлжээ болон үйлдвэрлэл/боловсруулах үйл явцын бүх үе шатанд хамаарна.

- 3.1.6 2024 оны 7-р сарын 1-ээс эхлэн тухайн бүтээгдэхүүн дэх ноолуур нь 100% 'SFA Certified' ноолуур байхаас бусад тохиолдолд компани нь бүтээгдэхүүнийг "SFA Certified" гэж худалдахгүй.
- 3.1.7 Тухайн ААН, Компани нь "SFA Certified" ноолуурыг худалдахдаа бэлтгэн нийлүүлэгчид, арилжаа эрхлэгчид болон анхан шатны боловсруулах үйлдвэрүүдэд олгосон хэвлэмэл 3 өнгийн борлуулалтын баримтыг (ББ), эсвэл мөшгөлтийн тогтолцоонд оролцогчоор бүртгүүлсний дараа олгосон цахим борлуулалтын баримт (ББ) ашиглана. Энэ баримт бичгийг [Хавсралтад](#) заасан жишээн дээр харуулав.
- 3.1.7.1 Тухайн ААН, Компани нь худалдсан "SFA Certified" ноолууран бүтээгдэхүүний бодит тоо хэмжээг (хөрвүүлэх хувь хэмжээг тооцох) худалдан авсан "SFA Certified" ноолуур, ноолууран бүтээгдэхүүний орцын Борлуулалтын баримт(ууд) дээр бичигдсэн тоо хэмжээтэй харьцуулж хянана.



Ноолуур болон ноолууран бүтээгдэхүүн борлуулах бүрд Борлуулалтын баримт шаардлагатай.

- 3.1.7.1.1 Тухайн ААН, Компани нь борлуулалтыг өөрийн болон аливаа системд бүртгэхээс өмнө 3.1.7.1-ийг гүйцэтгэсэн эсэхийг хянана.
- 3.1.7.1.2 Тухайн ААН, Компани нь "SFA Certified" ноолуур эсвэл ноолууран бүтээгдэхүүний багцад ноолуур нийлүүлсэн бүх ханган нийлүүлэгчдийн давтагдахгүй ID (дугаар)-ийг арилжаа хийх үед борлуулалтын баримтын эсрэг (ар) талд бичсэн байх хэрэгтэй.
- 3.1.8 Тухайн ААН, Компани нь ноолуурын багцад ТННЭ-ээс олгосон нэг эсвэл хэд хэдэн Борлуулалтын гэрчилгээгээр "SFA Certified" орцыг нотлохгүйгээр ноолуурыг "SFA Certified" гэж худалдах ёсгүй.
- 3.1.8.1 Борлуулалтын гэрчилгээ авахын тулд компани (худалдан авагч) гүйлгээ бүрийг хүчинтэй Борлуулалтын баримтын хамт ТННЭ-ийн Сэйлсфорс (Salesforce) онлайн бүртгэлд харгалзах баримт(ууд)-ын сканердсан хуулбарын хамт оруулна. ТННЭ-ийн онлайн бүртгэлийн маягыг ([5-р хэсгээс](#)) үзнэ үү.



Агууламжийн мэдэгдлийн стандарт (АМС)-ийн гэрчилгээтэй аж ахуйн нэгжүүд АМС-ийн бүртгэл хөтлөлтийн шаардлагын дагуу 3.1.8.1-д заасанчлан Борлуулалтын баримтыг ирүүлэх ёстойг анхаарна уу.

- 3.1.8.1.1 Тухайн ААН, Компани нь ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны хяналтын программ хангамжаар дамжуулан борлуулалтын баримтыг цахим хэлбэрээр илгээхдээ анхдагч гараар бичсэн борлуулалтын баримтын үрд болон ар талын гэрэл зураг эсвэл pdf файлыг хавсаргана.
- 3.1.9 ТҮБ нь хувь хэмжээг тохируулах тооцоололгүйгээр, өөрөөр хэлбэл ноолуурыг боловсруулах үе шатууд дахь хөрвүүлэх хувь хэмжээгээр оролтыг гаралттай тохируулсан байдлыг хянахгүйгээр Борлуулалтын гэрчилгээ олгохгүй. Тухайлбал, түүхий ноолуурыг угааж, самнасны дараа хаягдлын жин (жишээ нь: завсрын үс, тос, шороо) нь түүхий ноолуурын жингээс хасагдах бөгөөд цэвэр ноолуур нь бага жинтэй болно.



Түүхий ноолуурыг самнасан болгон хөрвүүлэх дундаж хувь нь 50% гэж тооцоолсон. Эдгээр Мөшгөлтийн тогтолцооны удирдамжийг цаашид боловсронгуй болгох, тооцооллыг сайжруулахын тулд оролцогчид өөрсдийн хөрвүүлэх хувь хэмжээг найдвартай бүртгэж ТННЭ-тэй хуваалцаарай.

- 3.1.9.1 ТҮБ нь Борлуулалтын гэрчилгээ дээрх дэлгэрэнгүй мэдээллийг Борлуулалтын баримт болон компанийн нэхэмжлэх, тээвэрлэлтийн баримт бичигтэй тохирч байгаа эсэхийг шалгана.



Худалдан авсан ноолуур нь "SFA Certified" гэдэгт итгэлтэй байхын тулд компани нь шууд нийлүүлэгчээсээ өмнөх гүйлгээний гэрчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг мэдэх шаардлагагүй.

- 3.1.10 ТҮБ нь 2024 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн холимог ноолууран ширхэгт болон холимог ноолууран ширхэгт агуулсан бүтээгдэхүүн ("SFA Certified" ноолууран утас, баталгаажуулсан ноолууран утастай холилдсон) худалдах Борлуулалтын гэрчилгээг аливаа компанид олгохгүй.



"SFA Certified" ноолууран ширхэгтийг баталгаажуулах шаардлагагүй бусад байгалийн утастай хольж хэрэглэж болно.

3.2. ТННЭ-ийн мөшгөлтийн удирдлагад тавигдах шаардлага


- 3.2.1 Тухайн ААН, Компани нь ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны удирдамжаар тавигдаж буй шаардлагыг өөрийн дүрэм журамд тусган баримтална.
- 3.2.2 Тухайн ААН, Компани нь ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны удирдамжийн хуулбарыг (жишээ нь энэ баримт бичиг) өөрийн байранд хадгална.
- 3.2.3 Тухайн ААН, Компани нь журам бүрийг хэрэгжүүлэх үүрэгтэй ажилтан, албан хаагчдыг тодорхойлж, тэдэнд журам(уудыг) хэрэгжүүлэхэд хангалттай сургалт, ур чадварыг эзэмшүүлсэн байна.
- 3.2.4 Тухайн ААН, Компани нь ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны бүх талыг хамарсан бүртгэлийг бүрэн, шинэчилсэн байдлаар хөтлөх бүртгэл хөтлөлтийн системийг хэрэгжүүлнэ.
 - 3.2.4.1 Тухайн ААН, Компани нь “SFA Certified” ноолууртай харьцах үйл ажиллагааг баримтжуулахын тулд өөрийн бүртгэлийг хөтөлнө.
- 3.2.5 Тухайн ААН, Компани нь ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны хэрэгжилтийг өөрийн байгууллагын системд бүхэлд нь хариуцан нэвтрүүлэх удирдлагын төлөөлөгчийг томилсон байна.
- 3.2.6 Тухайн ААН, Компани нь мөшгөлтийн тогтолцоотой холбоотой ажилтнуудын сургалтын аудит хийх боломжтой бүртгэлүүдийг дор хаяж таван жил хөтөлж, хадгална.
- 3.2.7 Тухайн ААН, Компани нь хүсэлт гаргасны дагуу ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоотой холбоотой бүх бүртгэлийг ТННЭ эсвэл ТҮБ-д шалгуулах боломжийг бүрдүүлнэ.

4 МЭДЭГДЭЛ ГАРГАХ

ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцоо эсвэл АМС-ийг дагаж мөрдөх замаар хариуцлагатай үйлдвэрлэсэн ноолуурын хэрэглээг харуулж чадах ААН, компаниуд дараах шаардлагын дагуу 'SFA Certified' логог бүтээгдэхүүндээ ашиглах боломжтой.



4.1 Мэдэгдлийн удирдамж

- 4.1.1 Мэдэгдэл гаргахаас өмнө ТННЭ-ээс бичгээр зөвшөөрөл авалгүйгээр ерөнхий мэдэгдэл эсвэл борлуулах бүтээгдэхүүнийг "SFA Certified" гэсэн мэдэгдлийг ТННЭ зөвшөөрөхгүй. Компани нь бичвэр, бүтээл болон Борлуулалтын гэрчилгээний дугаарыг харуулсан [Мэдэгдлийн зөвшөөрлийн хүсэлтийг claims@sustainablefibre.org](mailto:claims@sustainablefibre.org) хаягаар илгээх боломжтой.
- 4.1.1.1 "Нийлүүлсэн ноолуурын ерөнхий мэдэгдэл" ба/эсвэл "Нийлүүлэгдсэн бүтээгдэхүүний мэдэгдэл" (ТННЭ-ийн мэдэгдэл гаргах зааварт тодорхойлсон) ашигладаг үйлдвэрлэгчид ТННЭ-ээс зөвшөөрөл авах шаардлагагүй.
- 4.1.2 ТННЭ-н гишүүн эсвэл ТННЭ-ийн гишүүнчлэлд бүртгэлгүй аливаа ААН, компани арилжаалах ноолуураа "SFA Certified" гэсэн мэдэгдлийг ТННЭ зөвшөөрөхгүй.
- 4.1.2.1 ТННЭ-ийн гишүүн брэндийн нэрийн өмнөөс "SFA Certified" бүтээгдэхүүн борлуулж буй жижиглэн худалдаа эрхлэгчдээс ТННЭ-ийн гишүүнчлэл шаардахгүй.
- 4.1.3 ТННЭ-тэй өөрөөр тохиролцоогүй бол 'SFA Certified' лого бүхий шошгогүй (эсвэл түүнтэй адилтгах) худалдах эцсийн бүтээгдэхүүн дээрх "SFA Certified" гэсэн мэдэгдлийг ТННЭ зөвшөөрөхгүй.
- 4.1.3.1 Оёмол шошго дээр логог оруулалгүйгээр "SFA Certified" гэж бичиж болно.
- 4.1.3.2 "SFA Certified" лого нь бүтээгдэхүүний мэдэгдлийн хажууд харагдах боломжгүй, жишээлбэл цахим каталогийн зураг гэх мэт тохиолдолд зөвхөн бичвэр бүхий мэдэгдэл гаргаж болох бөгөөд харин лого нь бүтээгдэхүүн, шошго, бүтээгдэхүүний жагсаалт болон өөр цахим хуудаснуудад харагдаж байх ёстой.
- 4.1.4 Худалдагч тал нь хөрвүүлэх хувь хэмжээг тооцсоны дараа борлуулах бүтээгдэхүүний хэмжээ (гарц) нь худалдан авсан 'SFA Certified' ноолуурын хэмжээтэй (орцтой) тохирч байгааг нотлоогүй тохиолдолд ТННЭ нь борлуулах бүтээгдэхүүний 'SFA Certified' гэсэн мэдэгдлийг зөвшөөрөхгүй.
- 4.1.5 Ноос эсвэл торго зэрэг бусад байгалийн ширхэгтэй ноолуурыг хольсон эцсийн бүтээгдэхүүн дэх ноолуур нь 100% "SFA Certified" байх бөгөөд эцсийн бүтээгдэхүүний агууламжийн дор хаяж 5%-иас доошгүйг ноолууран ширхэгт бүрдүүлээгүй тохиолдолд худалдаалах гэж буй бүтээгдэхүүнд "SFA Certified" гэж мэдэгдэл гаргахыг ТННЭ зөвшөөрөхгүй.
-  *Жишээлбэл, 95% ноос, 5% ноолууран ороолт бол энэ 5% нь "SFA Certified" ноолуур байх ёстой. Өөр нэг жишээ дурдахад, 70% торго, 30% ноолууран ороолт бол бүтээгдэхүүн дэх энэхүү 30% ноолуур нь 'SFA Certified' ноолуур байх ёстой.*

- 4.1.6 2024 оны 7-р сарын 1-нээс эхлэн компани мэдэгдлийн хувийг зарлаагүй бол ТННЭ нь борлуулах бүтээгдэхүүний "SFA Certified" гэсэн мэдэгдлийг зөвшөөрөхгүй бөгөөд ингэснээр мэдэгдэлд тухайн бүтээгдэхүүнд 100% "SFA Certified" ноолуур агуулагдаж буйг илэрхийлнэ.



Жишээлбэл, “Уг бүтээгдэхүүний ноолуурын 100% нь “SFA Certified”. Хэрэглэгчид амархан танигдах бүрэлдэхүүний аль нэг хэсэг биш л бол энэ хувийг бүрэн бүтээгдэхүүний жингээр тооцно. Жишээ нь ханцуй, корсет.

- 4.1.6.1 2024 оны 7-р сарын 1-ээс эхлэн тухайн бүтээгдэхүүний ноолуурын 100% нь “SFA Certified” биш бол ТННЭ нь борлуулах бүтээгдэхүүний "SFA Certified" гэсэн мэдэгдлийг зөвшөөрөхгүй.
- 4.1.7 Брэнд/жижиглэн худалдаачин өөрийн бүтээгдэхүүнээ жижиглэн худалдаалахаас бусад тохиолдолд ТННЭ нь борлуулах бүтээгдэхүүнийг "SFA Certified" гэсэн мэдэгдлийг зөвшөөрөхгүй.
- 4.1.8 ТННЭ нь хүчинтэй Борлуулалтын гэрчилгээгүй бүтээгдэхүүнтэй холбоотой мэдэгдлийг зөвшөөрөхгүй.
- 4.1.9 ТННЭ нь Брэндийн таниулах удирдамжтай тохирохгүй мэдэгдлийг зөвшөөрөхгүй.
- 4.1.10 ТННЭ-ийн логог түүнийг төлөөлж буй бүтээгдэхүүн(үүд)-д шууд бэхэлснээс бусад тохиолдолд ерөнхий мэдэгдлийн нэг хэсэг болгон ашиглахыг ТННЭ зөвшөөрөхгүй.
- 4.1.11 ТННЭ нь ‘ёс зүйтэй үйлдвэрлэгдсэн’, ‘байгаль орчинд ээлтэй’, ‘100% тогтвортой’ гэх мэт байгаль орчин, нийгэм, амьтны тавлаг байдалд суурилсан өргөн хүрээтэй ерөнхий мэдэгдлийг зөвшөөрөхгүй.
- 4.1.12 ТННЭ-ийн баталгаажуулалтад хамааралгүй хэдий ч ‘SFA Certified’ гэх ойлголт төрүүлэхүйц байдлаар бусад бүтээгдэхүүн эсвэл агууламжид мэдэгдэл гаргахыг ТННЭ зөвшөөрөхгүй.
- 4.1.13 Худалдагч талын нэр, хамрах хүрээний дугаар болон ТННЭ-ийн лавлагааг оруулаагүй бүтээгдэхүүний мэдэгдлийг ТННЭ зөвшөөрөхгүй.



Дэлгэрэнгүй зааврыг ТННЭ-ийн вэб сайтын [Resources page](#) хуудасны доод талд байгаа "Claims" цэсийн доор жагсаасан баримт бичгүүдээс олж танилцана уу.

5 НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Оролцогч компаниудад эдгээр удирдамжийг дагаж мөрдөхөд нь ТННЭ-ээс дэмжлэг, зааварчилгааг үргэлж үзүүлэх болно.

ТННЭ-ийн холбоо барих мэдээлэл

ТННЭ Их Британи

41 Bryn Awelon
Mold
Flintshire
United Kingdom
SN7 1LT

Имэйл: coc@sustainablefibre.org

ТННЭ Монгол

Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж,
Гранд оффис төв, 23 тоот
Утас: +976-70115559

Имэйл: admin@sustainablefibre.mn

Бүртгэлийн маягтууд

- [ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны бүртгэлийн маягт](#)
- [Түүхий болон угаасан ноолуурын борлуулалтын бүртгэлийн маягт](#)
- [ТННЭ Борлуулалтын бүртгэл - Хятад](#)


Бусад

- [ТННЭ Борлуулалтын бүртгэл - Монгол](#)
- [ТННЭ-ийн веб сайт](#)
- [Асуулт, хариулт болон баримт бичгүүд](#)
- [ТННЭ-ээр зөвшөөрөгдсөн Тохирлын үнэлгээний байгууллагууд](#)

ХАВСРАЛТ – БОРЛУУЛАЛТЫН БАРИМТУУД

Жишээ ББ 1: (түүхий болон угаасан)

ББ 1 нь зөвхөн хэвлэмэл хэлбэрээр байдаг бөгөөд бүртгүүлсний дараа үйлдвэрлэгчид, арилжаа эрхлэгчид болон анхан шатны боловсруулагчдад олгоно.



TRANSACTION RECEIPT 1 (RAW OR SCAURED)

Date [DD/MM/YYYY]: Transaction Receipt #:

Historical Receipt Numbers for fibre contained in this batch:

1. BUYER DETAILS		2. SELLER DETAILS	
Company Name:		Company / Organisation Name:	
Type of Buyer (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		Type of Seller (tick all that apply): <input type="checkbox"/> Producer Organisation <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor	
SFA Register ID:		SFA Register ID:	
Contact email:		Contact email:	
Contact number:		Contact number:	
3. PRODUCT DESCRIPTION			
Product Type (tick one): <input type="checkbox"/> Raw <input type="checkbox"/> Scoured			
Colour	Weight (KG)	Price per KG (MNT)	Total price per colour (MNT)
White			
Grey			
Brown/Dark			
Mixed			
<i>TOTAL WEIGHTS</i>		<i>TOTAL PRICE</i>	

Buyer Representative Name: Seller Representative Name:


Signature: Signature:

White Copy = CAB, Pink Copy = Seller, Yellow Copy = Buyer

SFA Mongolia Office: Room #32, 2nd floor, Grand Office, Olympic Street, Ulaanbaatar. Tel +976-70115559

ББ 2: Самнасан болон ээрмэл утас

Зураг дээр дарж татаж авна уу.



ELECTRONIC TRANSACTION RECEIPT 2 (DEHAIRIED/CLEAN TO SPUN YARN)

Date [DD/MM/YYYY]: Transaction Receipt #:

Historical Receipt Numbers for fibre contained in this batch:

1. BUYER DETAILS		2. SELLER DETAILS		
Company Name:		Company Name:		
Type of Buyer (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		Type of Seller (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		
Contact email:		Contact email:		
Contact number:		Contact number:		
3. PRODUCT DESCRIPTION				
Product Type (tick one): <input type="checkbox"/> Dehairied/Clean <input type="checkbox"/> Spun Yarn				
Description	Batch ID numbers	Total Weight (KG)	SFA Content Weight (KG)	Proportion of SFA Content
<i>TOTAL WEIGHTS</i>				


Buyer Representative Name: Seller Representative Name:

Signature: Signature:

Seller to secure signatures and send completed receipt to the SFA Mongolia Office: admin@sustainablefibre.mn

ББ 3: Утас болон эцсийн бүтээгдэхүүн

Зураг дээр дарж татаж авна уу.



ELECTRONIC TRANSACTION RECEIPT 3 (FABRIC ONWARDS)

Date [DD/MM/YYYY]: Transaction Receipt #:

Historical Receipt Numbers for fibre contained in this batch:

1. BUYER DETAILS		2. SELLER DETAILS		
Company Name:		Company Name:		
Type of Buyer (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		Type of Seller (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		
Contact email:		Contact email:		
Contact number:		Contact number:		
3. PRODUCT DESCRIPTION				
Product Type (tick one): <input type="checkbox"/> Fabric <input type="checkbox"/> Final product				
Description	Batch ID numbers	Total Weight (KG)	SFA Content Weight (KG)	Proportion of SFA Content
<i>TOTAL WEIGHTS</i>				

Buyer Representative Name: Seller Representative Name:

Signature: Signature:

Seller to secure signatures and send completed receipt to the SFA Mongolia Office: admin@sustainablefibre.mn



Нийтэлсэн:
Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл (ТННЭ)
Дэлгэрэнгүй мэдээллийг <http://sustainablefibre.org> болон
info@sustainablefibre.org хаягаар авна уу.